



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021-33-СТА-ТШЗ**

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2021 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: Ахлах аудитор: П.Мөнхтуяа Утас: 70342716 Цахим хаяг:</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	3
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	3
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	3
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	3
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	3
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	3
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	3
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	16
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	16
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	16
3.4. Материаллаг байдал .....	17
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	17
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	18
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	19
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	19
3.9. Аудитын илрүүлэлт.....	19
Залруулсан алдаа.....	19
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	19
Аудитын зөвлөмж.....	21
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	21
4. Менежментийн захидал .....	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	21

- 1.Төрийн аудитын санал, дүгнэлт**
  - 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан**
    - 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**
    - 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**
    - 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**
    - 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**
    - 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**
    - 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан**
-



**БУЛГАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

63082 Булган аймаг, Булган сум, Жаргалант баг,  
Утас: 7034-2580, Факс: 7034-2580

2021.02.02 № 27

тантай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ т

**Аудитын гэрчилгээ**

БҮРЭГХАНГАЙ СУМЫН ЭМТ-ИЙН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ Б.ОЮУНГЭРЭЛ  
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Хязгаарлалттай санал дүгнэлт**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Бүрэгхангай сумын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

006020055

#### Аудитын гол асуудал

Тус байгууллага нь тайлант онд эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авахдаа тендерт шалгараагүй, гэрээ байгуулаагүй 5 компаниас 7415.0 мянган төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдан авсан, мөн 4052.0 мянган төгрөгийн шатахууны зардлыг зарцуулахдаа даргын цохолтгүй, жолоочийн тооцооны замын хуудсыг хөтлөөгүй, анхан шатны баримт дутуу, байгууллагын дарга өөрийн данс руу ахмадуудад хүндэтгэл үзүүлж тэтгэмж олгох 300.0 мянган төгрөгийг шилжүүлсэн, ахмадын сан байгуулж ажиллаагүй зэрэг зөрчил илэрсэн нь ТБОНӨХБАҮХА тухай хуулийн 7.1, НББ-ийн тухай хуулийн 13.1, 13.6, 13.7, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2-р хавсралтаар баталсан "Ахмадын сан байгуулж ажиллуулах журам", байгууллагын дотоод журмын 6.2.6, ЭМГ-ын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот "Зөвлөмж хүргүүлэх тухай" эм, эмнэлгийн хэрэгслийг бэлтгэн нийлүүлэгчээр сонгон шалгаруулалтад тэнцсэн компаниудын жагсаалт үйлдсэн албан бичиг зэргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй, нийт 11767.0 мянган төгрөгийн алдаа, зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд сонгосон материаллаг дүнгээс илүү илэрхийлэгдэж байгаа нь санхүүгийн тайлангийн үнэн зөв, иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР, Д.АНХБАЯР



САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>63,871,402.47</b>	<b>52,175,433.47</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	10,000,000.00	-
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	10,000,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	10,000,000.00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	52,395,402.47	50,699,433.47
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	19,510,245.00	18,744,860.90
35110	Тусгай зориулалттай материал	19,388,600.00	7,136,289.00
35130	Эм боох материал	121,645.00	11,608,571.90
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	32,885,157.47	31,954,572.57
35420	Аж ахуйн материал	27,008,168.87	25,203,245.27
35430	Сэлбэг хэрэгсэл	2,950,000.00	3,585,000.00
35460	Хүнсний материал	2,923,788.60	2,778,127.30
35470	Бусад хангамжийн материал	3,200.00	388,200.00
<b>36</b>	<b>НӨӨЦИЙН БАРАА</b>	1,476,000.00	1,476,000.00
36100	Барааны нөөц	6,000.00	6,000.00
36300	Тэжээлийн нөөц	1,470,000.00	1,470,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>357,059,346.33</b>	<b>380,426,687.93</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	357,059,346.33	380,426,687.93
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	349,049,346.33	372,416,687.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	281,901,459.57	281,901,459.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	(17,070,906.42)	(27,630,080.94)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	67,034,656.00	67,034,656.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(21,418,742.22)	(33,154,932.62)

39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	51,089,350.05	95,700,038.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(28,854,088.60)	(30,113,082.65)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	7,170,117.00	10,349,117.30
39208	Хуримтлагдсан элэгдэл	(4,593,868.05)	(4,532,410.29)
39209	Зам, гүүрийн байгууламж	15,677,803.20	15,677,803.20
39210	Хуримтлагдсан элэгдэл	(2,530,834.20)	(3,505,279.80)
39217	Ном	644,400.00	689,400.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	8,010,000.00	8,010,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	8,010,000.00	8,010,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>420,930,748.80</u></b>	<b><u>432,602,121.40</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>420,930,748.80</u></b>	<b><u>432,602,121.40</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	420,930,748.80	432,602,121.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	208,459,592.29	208,459,592.29
51101	Өмч: - төрийн	208,459,592.29	208,459,592.29
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	16,152,611.61	25,596,081.68
51210	Өмнөх үеийн үр дүн	16,152,611.61	16,152,611.61
51220	Тайлант үеийн үр дүн	-	9,443,470.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	196,318,544.90	198,546,447.43
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>420,930,748.80</u></b>	<b><u>432,602,121.40</u></b>

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>412,403,973.33</b>	<b>476,244,870.68</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>42,963,157.33</b>	<b>62,606,058.68</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	42,963,157.33	62,606,058.68
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,963,157.33	62,606,058.68
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	42,963,157.33	62,606,058.68
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>369,440,816.00</b>	<b>413,638,812.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	292,690,000.00	314,466,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,690,000.00	314,466,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,353,000.00	16,690,580.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00	1,847,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	225,900.00	14,735,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	127,100.00	107,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	60,958,400.00	58,658,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,958,400.00	58,658,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,439,416.00	23,824,232.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,439,416.00	23,824,232.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>388,500,245.75</b>	<b>452,634,000.61</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>388,500,245.75</b>	<b>452,634,000.61</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	384,055,290.65	451,595,575.97
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	218,585,038.90	252,542,057.46
210101	Үндсэн цалин	168,356,099.66	245,936,252.78
210102	Нэмэгдэл	36,173,200.00	380,913.68

210104	Урамшуулал	14,055,739.24	6,224,891.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>27,343,068.46</b>	<b>31,760,400.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	18,585,700.00	21,687,872.58
210202	Тэтгэмжийн даатгал	2,186,600.00	2,549,808.77
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,760,368.46	2,023,047.02
210204	Ажилгүйдлийн даатгал	437,300.00	499,970.15
210205	Эрүүл мэндийн даатгал	4,373,100.00	4,999,701.48
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,469,561.00</b>	<b>55,716,073.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,956,555.00	5,047,330.00
210302	Түлш, халаалт	50,392,010.00	50,163,340.00
210303	Цэвэр, бохир ус	120,996.00	505,403.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>17,584,174.00</b>	<b>19,623,663.60</b>
210401	Бичиг хэрэг	1,828,130.00	2,065,820.00
210402	Тээвэр, шатахуун	11,586,394.00	10,179,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,001,000.00	1,116,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,848,450.00	3,012,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	300,200.00	250,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	20,000.00	-
210408	Бараа материал акталсны зардал	-	2,999,923.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>35,529,687.80</b>	<b>53,491,267.65</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	30,029,841.00	49,366,556.35
210502	Хоол, хүнс	5,499,846.80	4,124,711.30
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>2,912,400.00</b>	<b>3,098,900.00</b>
210604	Урсгал засвар	2,912,400.00	3,098,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,276,000.00</b>	<b>1,400,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,276,000.00	1,400,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,071,590.00</b>	<b>571,594.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	445,000.00	139,594.00

210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	496,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	65,340.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	32,250.00	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>24,283,770.49</b>	<b>33,391,620.26</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,954,400.00	1,299,826.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	21,329,370.49	32,091,794.26
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,444,955.10</b>	<b>1,038,424.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>100,000.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>4,344,955.10</b>	<b>38,424.64</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,344,955.10	38,424.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>23,903,727.58</u></b>	<b><u>23,610,870.07</u></b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	-	14,167,400.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	14,167,400.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(14,167,400.00)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>23,903,727.58</u></b>	<b><u>9,443,470.07</u></b>

**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>369,440,816.00</b>	<b>413,638,812.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>369,440,816.00</b>	<b>413,638,812.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	292,690,000.00	314,466,000.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	292,690,000.00	314,466,000.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,353,000.00	16,690,580.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	10,000,000.00	1,847,880.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	225,900.00	14,735,700.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	127,100.00	107,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	60,958,400.00	58,658,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	60,958,400.00	58,658,000.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5,439,416.00	23,824,232.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	5,439,416.00	23,824,232.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>369,440,216.00</b>	<b>412,513,812.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>369,440,216.00</b>	<b>412,513,812.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>364,995,260.90</b>	<b>411,475,387.36</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	218,585,038.90	252,542,057.46
210101	Үндсэн цалин	168,356,099.66	166,554,100.00
210102	Нэмэгдэл	36,173,200.00	69,362,700.00
210104	Урамшуулал	14,055,739.24	16,625,257.46
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	27,331,300.00	31,760,400.00
210201	Тэтгэврийн даатгал	18,585,700.00	21,657,600.00

210202	Тэтгэмжийн даатгал	2,186,000.00	2,525,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,749,200.00	2,020,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	437,300.00	525,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,373,100.00	5,031,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>55,469,561.00</b>	<b>55,716,073.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,956,555.00	5,047,330.00
210302	Түлш, халаалт	50,392,010.00	50,163,340.00
210303	Цэвэр, бохир ус	120,996.00	505,403.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>18,426,974.00</b>	<b>17,605,240.00</b>
210401	Бичиг хэрэг	1,828,130.00	1,816,820.00
210402	Тээвэр, шатахуун	11,586,394.00	10,179,120.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,001,000.00	1,116,800.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,840,250.00	3,202,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,171,200.00	1,290,000.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>24,776,297.00</b>	<b>45,760,896.90</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	20,231,137.00	40,945,846.90
210502	Хоол, хүнс	3,495,160.00	3,979,050.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,050,000.00	836,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>3,052,400.00</b>	<b>4,353,800.00</b>
210601	Багаж, техник хэрэгсэл	-	1,411,900.00
210604	Урсгал засвар	3,052,400.00	2,941,900.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,276,000.00</b>	<b>1,400,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,276,000.00	1,400,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,071,590.00</b>	<b>571,594.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	445,000.00	139,594.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	496,000.00	432,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	58,000.00	-
210804	Тээврийн хэрэгслийн татвар	39,590.00	-

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	-
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	15,006,100.00	1,765,326.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,006,100.00	1,765,326.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,444,955.10</b>	<b>1,038,424.64</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	100,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	100,000.00	1,000,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	4,344,955.10	38,424.64
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,344,955.10	38,424.64
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>600.00</b>	<b>1,125,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	-	<b>1,125,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>1,125,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	1,125,000.00
223001	Бусад хөрөнгө	-	1,125,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	=	<b>(1,125,000.00)</b>
	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	-	-
14	<b>Бусад эх үүсвэр</b>	-	-
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх		
145005	Дамжуулан зээлдүүлэх зээлээс эргэж төлөгдөх		
145006	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих		
145007	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
145008	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан		
145009	Төрөл бүрийн хандив		
<b>23</b>	<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	-	-
230001	Эргэж төлөгдөх зээл		
231001	Гадаадын санхүүгийн зах зээлээс санхүүжих зээл		
232001	Гадаадын төслийн зээлээс санхүүжих зээл		
<b>24</b>	<b>ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР</b>	-	-
240001	Гадаад зээлийн үндсэн төлбөр		
241001	Засгийн газрын бондын үндсэн төлбөр		

242001	Засгийн газрын үнэт цаасны үндсэн төлбөр		
25	<b>Санхүүгийн үйл ажиллагааны зардал</b>	-	-
250001	Гадаад валютын ханшийн зөрүү		
250002	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө		
250003	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
250004	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн		
250005	Төлсөн ногдол ашиг		
<b>7</b>	<b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	=	=
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>		-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

СТ-4А

**ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	16,152,611.61		420,930,748.80
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>208,459,592.29</b>	<b>196,318,544.90</b>	<b>16,152,611.61</b>	-	420,930,748.80
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-		-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-		-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	-		-
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>208,459,592.29</b>	<b>196,318,544.90</b>	<b>16,152,611.61</b>	-	420,930,748.80

D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	16,152,611.61	-	420,930,748.80
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-		-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	208,459,592.29	196,318,544.90	16,152,611.61	-	420,930,748.80
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	2,227,902.53	-		2,227,902.53
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-		-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-		-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-		-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	9,443,470.07		9,443,470.07
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	208,459,592.29	198,546,447.43	25,596,081.68	-	432,602,121.40

### 3.Аудитын тайлан

### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Б.Оюунгэрэл танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Булган аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Мөнхтуяа хариуцаж хэрэгжүүлэв.

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймгийн Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 11 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Тус сумын ЭМТ нь 2020 онд эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах, нийгмийн эрүүл мэндийн тусламж, эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, эмч, эмнэлгийн мэргэжилтний ур чадварыг дээшлүүлэх, нийгмийн баталгааг хангах, эмнэлгийн тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх, эм зүйн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн зорилго, зорилтуудыг дэвшүүлж ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт ороогүй гэж үзэж байна.

### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

ХАК нь 2020 онд Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2019 оны санхүүгийн үйл ажиллагаанд баталгаажуулах аудит хийж, нийт 11089.6 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 162.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 10000.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 927.6 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн хариуг хугацаанд ирүүлж ажиллаагүй байна.

ХАК нь 2019 оны шилэн дансанд хийсэн дотоод аудитаар зөрчил илрээгүй мэдээллийг бүрэн мэдээлсэн гэж менежментийн захидалд дурдсан байна.

ХАК нь эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт зардлын 225369.2 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 4507.4 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон төлөвлөж гүйцэтгэлийн үе шатанд 466801.4 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 9336.0 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцон авч үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11617.4 мянган төгрөгөөр буюу 2.6 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	63871.4	52175.4	11696.0
Үндсэн хөрөнгө	357059.3	380426.7	23367.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>420930.7</b>	<b>432602.1</b>	<b>11617.4</b>
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	208459.6	208459.6	0
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>420930.7</b>	<b>432602.1</b>	<b>11617.4</b>

Мөнгөн хөрөнгө данс үлдэгдэлгүй.

Авлага данс үлдэгдэлгүй.

Бараа материалын дансны үлдэгдэл 52175.4 мянган төгрөг болж 1696.0 мянган төгрөгөөр буурсан нь оны эцэст 14167.4 мянган төгрөгийг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлж, 2999.9 мянган төгрөгийн материалыг акталж .

Тухайн жил төсвийн хөрөнгөөр 67068.6, ЗДТГ-аас 1420.0, ЭМГ-аас 14768.2, Хангай хоточ ХХК-иас 240.0, иргэн Б.Баатарсайханаас 2000.0 мянган төгрөгийн нийт мянган төгрөгийн орлогыг материалын орлогод бүртгэн тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 479362.5 мянган төгрөг болж 47834.7 мянган төгрөгөөр өссөн нь Сумын засаг дарга суманд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн ААН-үүдтэй нийгмийн хариуцлагын гэрээ байгуулж гэрээнд заагдсаны дагуу ЭМТ-д нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахыг хүсэлтийг үндэслэн 21087.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг орлогод авч тайлагнажээ.

Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээгээр элэгдлээ бүрэн нөхсөн 16 нэр төрлийн үндсэн хөрөнгийг 2227.9 мянган төгрөгөөр дахин үнэлж тайлагнасан байна.

Өр төлбөр данс нь үлдэгдэлгүй.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл нэмэгдэж хасагдсан хөрөнгөгүй байна.

Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 63840.9 мянган төгрөгөөр буюу 13.4 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан улсын төсвөөс санхүүжих дүнгийн өөрчлөлт байна.

Энэ нь тусгай шилжүүлэг болон нэмэлт дансны санхүүжилт нийт 67053.2 мянган төгрөгийн нэмэгдсэн санхүүжилтийн үзүүлэлтэй холбон үзэж байна.

Нийт зардал өмнөх оноос 64133.8 мянган төгрөгөөр буюу 14.1 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан нь цалингийн зардал нэмэгдсэнтэй холбон үзэж байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оноос дахин үнэлгээний 2227.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлт гарч нягтлан бодох бүртгэл, стандартын дагуу бүртгэж тайлагнасан байна.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 314466.0, орон нутгийн төсвөөс 59658.0, ЭМДСангаас 25202.8 буюу нийт 399326.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 2378.6 мянган төгрөгөөр бууруулж баталсан нь орон нутгаас санхүүжих нь 1027.0, ЭМДСангаас 1378.6 буюу нийт 2405.6 мянган төгрөгөөр бууруулж төсөв баталсан байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулах санхүүжүүлэхээр 396948.2 мянган төгрөгийн төсөв баталснаас тусгай шилжүүлгээр 314466.0, орон нутгийн төсвөөс 58658.0, ЭМДСангаас 23824.2, нэмэлт санхүүжилтээр 16690.6 мянган төгрөг буюу нийт 413638.8 мянган төгрөгийн санхүүжилт авснаас гүйцэтгэлээр 413600.4 мянган төгрөгийг зарцуулж 38.4 мянган төгрөгийн үлдэгдлийг төсөвт төвлөрүүлэн ажиллажээ.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 413600.4 мянган төгрөг буюу 99 хувьтай байгаа нь багаж техник хэрэгслийн зардлаас 8.0, цалингийн зардлаас 30. мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

#### **Улсын /орон нутгийн/ төсөвт төвлөрүүлэх орлого**

Өөрийн орлого төлөвлөөгүй байна.

#### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт дансны санхүүжилтээр ЭМДСангаас 16690.6 мянган төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр бүрэн зарцуулсан байна.

### 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих мэдээллээс тухай бүр мэдээлэх мэдээллийг цаг хугацаанд нь мэдээлээгүй хоцроож мэдээлсэн байна.

Шилэн дансанд мэдээлэх бүх мэдээллийг цаг хугацаанд мэдээлж ажиллахыг зөвлөж ажиллалаа.

### 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 162.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 10000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 927.6 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилтийн хариуг ирүүлээгүй байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	162.0	1	162.0			
Албан шаардлага	1	10000.0	1	10000.0			
Зөвлөмж	3	927.6					
Нийт дүн							

/мянган.төг/

Өмнөх оны зөвлөмжийн хариуг нөхөж 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлж ажиллахыг зөвлөлөө.

### 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 25964.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14197.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 812.2 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 10954.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 зөвлөмж өгч ажиллалаа.

#### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Бараа материалын данснаас 14167.4 мянган төгрөгийн материалыг үндсэн хөрөнгийн данс руу шилжүүлэхдээ данс буруу сонгож шилжүүлсэн, үндсэн хөрөнгөнд 30.0 мянган төгрөгийн номын орлогыг дутуу тусгаж тайлагнасныг залруулж ажиллалаа.

#### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 11767.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 812.2 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 10954.8 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 албан шаардлага, дотоод хяналтыг сайжруулахаар 1 зөвлөмж хүргүүлж ажиллалаа. Үүнд:

1. Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх 300.0 мянган төгрөгийг байгууллагын дарга өөрийн данс руу шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Ахмадын сан байгуулж ажиллуулах журам”, байгууллагын дотоод журмын 6 дугаар зүйлийн 6.2.6-д “Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг ахмадын баярын арга хэмжээнд зориулж байгууллагаас тэтгэвэрт гарсан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлж тэтгэмж олгоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

2. Шатахуун зарцуулалтын 512.2 мянган төгрөгийг анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахууны цохолтгүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6-д “ Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.”, 13 дугаар зүйлийн 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Төлбөрийн акт тогтоов.

3. Байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн орлого зарлага, худалдан авалтыг түүвэрлэн шалгахад тендерт шалгарч гэрээ байгуулаагүй 5 компаниас 7415020 төгрөгийн эм, эмийн хэрэгслийг худалдан авсан зөрчил илэрсэн нь ТБОНӨХБАУХА тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д “Захиалагч бараа, ажил, үйлчилгээ худалдан авахдаа дор дурдсан тендер шалгаруулалтын журмыг баримтлан гүйцэтгэгчийг сонгож гэрээ байгуулна”, ЭМГ-ийн газрын 2020 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 01 тоот “Зөвлөмж хүргүүлэх тухай” албан бичгээр гарсан тендерт шалгарсан компанийн нэрсийн жагсаалт болон хуулийн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

4. Тухайн байгууллагын шатахуун зарцуулалтын орлого зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад 3539825 төгрөгийн шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцооны замын хуудас дутуу хөтөлсөн нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно.”, 13 дугаар зүйлийн 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.” ”Эд хариуцагчийн хүлээх үүрэгт “Ажиллаж байгаа байгууллагынхаа дотоод дүрэмд захирагдаж өөрийн гүйцэтгэх ажил үүрэг, сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлыг цаг хугацаанд нь биелүүлж удирдлагад тайлагнаж мэдээллээр ханган тэдэнтэй байнга хамтран ажиллана”, “Өөрийн хариуцаж байгаа зүйлийн орлого, зарлагын болон үлдэгдлийн мэдээ тайланг тухай бүр зохих маягтаар хариуцсан нягтлан бодогчид гарган өгч байна” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй байна.” гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй нь санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь:

Албан шаардлага хүргүүлэв.

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### 3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авалтын гүйцэтгэлийг авч үзэх нь зүйтэй гэж үзлээ

Тухайн жил эм, эмнэлгийн хэрэгслийг бэлтгэн нийлүүлэх компани тендер шалгаруулалт, худалдан авалтын зардлын гүйцэтгэл нь анхаарал татахуйц байна.

### 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1.Дотоод хяналттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллого явуулсан гэх боловч үндсэн хөрөнгийн, бараа материалын тооллогын дүнг нэгтгэн тайлагнаагүй, санхүүгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган баталгаажуулж ажиллаагүй байна.

1.2. Эрсдэл: Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй.

1.3. Өгсөн зөвлөмж: НББ-ийн тухай хуулийн 12.1 “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.” Заалтын дагуу байгууллагын хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй явуулж ажиллах.

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Өгсөн зөвлөмжийн дагуу ажиллах болно. Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Бүрэгхангай сумын ЭМТ-ийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2020			САГ-2021/33/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Булган аймаг дахь Төрийн аудитын газар		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5

1	Ахмадуудад хүндэтгэл үзүүлэх тэтгэмжийн зардлыг байгууллагын дарга өөрийн данс руу шилжүүлсэн.	300.0	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Б.Оюунгэрэл Б.Энхцэцэг
2	Шатахуун зарцуулалтын анхан шатны баримтын бүрдэлгүй, шатахууны цохолтгүй зарцуулсан	512.2	Төлбөрийн акт	Дарга, Нягтлан бодогч	Б.Оюунгэрэл Б.Энхцэцэг
3	Байгууллагын эм, эмнэлгийн хэрэгслийн орлого зарлага, худалдан авалтыг түүвэрлэн шалгахад тендерт шалгарч гэрээ байгуулаагүй 5 компаниас эм, эмийн хэрэгслийг худалдан авсан	7415.0	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Оюунгэрэл Б.Энхцэцэг
4	Тухайн байгууллагын шатахуун зарцуулалтын орлого зарлагыг анхан шатны баримттай тулган шалгахад шатахуун зарцуулалтыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, жолоочийн тооцооны замын хуудас дутуу хөтөлсөн	3539.8	Албан шаардлага	Дарга, Нягтлан бодогч	Б.Оюунгэрэл Б.Энхцэцэг
5	Жилийн эцсийн үндсэн хөрөнгийн болон бараа материалын тооллого явуулсан гэх боловч үндсэн хөрөнгийн, бараа материалын тооллогын дүнг нэгтгэн тайлагнаагүй, санхүүгийн тодруулга тайлангийн дүнтэй тулган баталгаажуулж ажиллаагүй	0	Зөвлөмж	Дарга, Нягтлан бодогч	Б.Оюунгэрэл Б.Энхцэцэг
<b>ДҮН</b>		<b>11767.0</b>			

АУДИТЫН ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР  
 МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

АУДИТЫН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:  
 АХЛАХ АУДИТОР П.МӨНХТУЯА